



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА 2020



Улаанбаатар хот

2020



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА

2020 оны 12 дугаар сар.

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн:

Ашигт малтмал, газрын тосны газрын

Уул уурхай, судалгааны хэлтсийн

Ахлах мэргэжилтэн

Ц.Цэгц

Ашигт малтмал, газрын тосны газар
Монгол Улс, Улаанбаатар хот 15170,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3,
Засгийн газрын XII байр, Баруун жигүүр
Утас: 976-51-263934

Цахим шуудан: info@mrpam.gov.mn

Цахим хаяг: mrpam.gov.mn

АГУУЛГА

1.	УДИРТГАЛ	5
1.1.	СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ	5
1.2.	СУДАЛГААНЫ АРГА	7
1.2.1.	Судалгааны асуулт	7
2.	ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН	9
3.	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	11
3.1.	ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЭЛ ХЯЛБАР ОЛЖ АВАХ БОЛОМЖ	11
3.2.	ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮНЭМШИЛ	12
3.3.	УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	13
3.4.	Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдал	14
3.5.	Байгаль орчны хууль, дүрмийн тодорхой байдал	15
3.6.	ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛСАН БАЙДАЛ	16
3.7.	Уул уурхайн татварын орчин	17
3.8.	Дэд бүтцийн хөгжил	18
3.9.	МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮРЭЛЦЭЭТЭЙ БАЙДАЛ	20
3.10.	Амьдрах орчны аюулгүй байдал	21
3.11.	Газрын харилцааны зохицуулалтын байдал	22
3.12.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ	23
3.13.	Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж	26
3.14.	Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцаа	27
3.15.	Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдал	28
3.16.	Нийгмээс уул уурхайд хандах хандлага	29
3.17.	Авлигаас ангид байдал	30
3.18.	Туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанар	31
3.19.	Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломж	32
4.	ДҮГНЭЛТ	34
5.	САНАЛ, ЗӨВЛӨМЖ	36

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийг сайжруулах санал	11
Хүснэгт 2. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлыг сайжруулах санал	12
Хүснэгт 3. Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал	13
Хүснэгт 4. Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлыг сайжруулах санал	14
Хүснэгт 5. Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлыг сайжруулах санал	15
Хүснэгт 6. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдлыг сайжруулах санал	17
Хүснэгт 7. Уул уурхайн татварын орчныг сайжруулах санал	18
Хүснэгт 8. Дэд бүтцийг хөгжүүлэх санал	19
Хүснэгт 9. Мэргэжлийн ажиллах хүчийг нэмэгдүүлэх санал	20
Хүснэгт 10. Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал	21
Хүснэгт 11. Газрын харилцааны зохицуулалтыг сайжруулах санал	22
Хүснэгт 12. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөг сайжруулах санал	24
Хүснэгт 13. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал	26
Хүснэгт 14. Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааг сайжруулах санал	27
Хүснэгт 15. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах ажиллагааг хялбаршуулах санал	29
Хүснэгт 16. Нийгмээс уул уурхайд хандах хандлагыг сайжруулах санал	30
Хүснэгт 17. Авлигаас ангид байлгах санал	30
Хүснэгт 18. Туслан гүйцэтгэгчийн чадавхийг нэмэгдүүлэх санал	32
Хүснэгт 19.. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх санал	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйл ажиллааны чиглэл	5
Зураг 2. Хөрөнгө оруулалт оруулсан хэлбэр.....	5
Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил.....	6
Зураг 4. Ашигт малтмалын төрөл.....	6
Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ	9
Зураг 6. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийн үнэлгээ.....	11
Зураг 7. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлын үнэлгээ	12
Зураг 8. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ.....	13
Зураг 9. Уул уурхайн хууль дүрмийн тодорхой байдал	14
Зураг 10. Байгаль орчны хууль дүрмийн тодорхой байдал	15
Зураг 11. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдал.....	16
Зураг 12. Уул уурхайн татварын орчин.....	18
Зураг 13. Дэд бүтцийн хөгжил.....	19
Зураг 14. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал.....	20
Зураг 15. Амьдрах орчны аюулгүй байдал.....	21
Зураг 16. Газрын харилцааны зохицуулалтын байдал.....	22
Зураг 17. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ	23
Зураг 18. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ	26
Зураг 19. Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааны үнэлгээ	27
Зураг 20. Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ	28
Зураг 21. Нийгмээс уул уурхайд хандах хандлагын үнэлгээ.....	29
Зураг 22. Авлигаас ангид байдлын үнэлгээ.....	30
Зураг 23. Туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ.....	31
Зураг 24. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ.....	32


1. УДИРТГАЛ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах санал боловсруулах

1.1. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Хөрөнгө оруулалтын орчны судалгаанд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг чиглэл тус бүрийн байгууллагуудыг хамруулахыг зорьсон бөгөөд нийт 130 байгууллага хамрагдсан. Судалгааг авах үед Монгол Улсад COVID-19 цар тахал бүртгэгдэж, Гамшгийн тухай хуулийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хатуу хөл хорио тогтоосны улмаас өнгөрсөн жилтэй харьцуулахад судалгаанд цөөн тооны байгууллагууд хамрагдсан байна.


Зураг 1. Үйл ажиллагааны чиглэл



Судалгаанд оролцсон байгууллагуудаас ашигт малтмалын геологийн эрэл, хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 86% нь байсан бол боловсруулалт, худалдаа, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, банк санхүү, хуулийн фирм, салбарын төрийн бус байгууллагууд үлдсэн хэсгийг нь бүрдүүлсэн. Өнгөрсөн жилтэй харьцуулахад олборлолтын үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд судалдагданд оролцогсодын талаас илүү хувийг эзэлжээ.


Дээрх байгууллагуудын хөрөнгө оруулалт оруулсан байдлыг авч үзвэл тэн хагасаас илүү хэсэг нь өөрийн хөрөнгийг төсөлдөө зарцуулсан байхад дөрөвний нэг нь гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж, 18% нь банк санхүүгийн байгууллагаас зээл авч, үлдсэн 5% нь хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгож, төрийн өмчийн хөрөнгө, концессын гэрээ болон бусад байдлаар хөрөнгө оруулжээ.

Зураг 2. Хөрөнгө оруулалт оруулсан хэлбэр




Үйл ажиллагаа явуулсан хугацааны хувьд байгуулагдаад удаагүй буюу 1-ээс 3 жил болж байгаа компаниуд нийт байгууллагуудын дөрөв хуваасны нэгээс илүү хэсгийг эзэлж, 15-аас дээш жил аж ахуй эрхэлж буй туршлагатай байгууллагууд 22%, 11-ээс 14 жил болж байгаа аж ахуйн нэгж 21%, 7-гоос 10 жил үйл ажиллагаа эрхэлсэн байгууллагууд 17%, 4-өөс 6 жил болж байгаа шинэвтэр байгууллагууд 13%-ийг тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил



Зураг 4. Ашигт малтмалын төрөл



Алтны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд хамгийн их хувь буюу 37%-ийг эзэлж, үүний дараа нүүрсний уурхай 18%, хайлуур жоншны уурхай, баяжуулах үйлдвэрүүд 15%, төмрийн хүдрийн уурхай 6%, зэсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулагчид 5%-ийг бүрдүүлсэн. Үлдсэн хэсгийг нь барилгын материал, төмөр, гянтболд, цайр, хар тугалга болон бусад төрлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бүрдүүлсэн байна.

1.2. СУДАЛГААНЫ АРГА

Судалгааны ажлыг асуулга /анкет, асуумж/-ын аргаар авч, хөрөнгө оруулалтын орчны чиглэлийн асуултуудад үнэлгээ өгөх байдлаар хариултуудыг авч тухайн асуудлыг сайжруулах арга замын талаар санал авлаа.

1.2.1. Судалгааны асуулт

Судалгааны асуулга нийтдээ 27 асуулттай бөгөөд үүнээс 5 асуулт нь ерөнхий мэдээлэл авах асуулт, үлдсэн 22 нь үндсэн асуулт байсан. Үндсэн асуултуудаас 20 асуулт нь уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинд үнэлгээ өгөх хариулт болон сайжруулах саналыг авсан бол 1 асуулт нь өмнөх асуултуудад ороогүй чиглэл байвал санал өгч болохоор, 1 асуулт нь энэхүү судалгааны ажлыг цаашид сайжруулахад юу хийх талаар санал авахаар зохиогдсон. Асуултуудыг боловсруулахдаа олон улсад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг үнэлэхэд хэрэглэдэг үзүүлэлт болон манай орны нөхцөлд байдалд тохируулсан асуултыг бэлтгэсэн болно.

Хөрөнгө оруулалтын орчинг үнэлж өгч, сайжруулах санал өгөх асуултууд:

1. Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж
2. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал
3. Улс төрийн тогтвортой байдал
4. Уул уурхайн үйл ажиллагааны хууль, дүрмийн тодорхой байдал

5. Байгаль орчны хууль, дүрэм, журмын тодорхой байдал
6. Хөрөнгө оруулагчийн хууль, ёсны эрх ашгийг хамгаалсан байдал
7. Уул уурхайн татварын орчин
8. Дэд бүтцийн хөгжил
9. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал
10. Амьдрах орчны аюулгүй байдал
11. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал
12. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөө
13. Төрийн байгууллага, уул уурхайн компаниудын хоорондын харилцаа
14. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж
15. Нутгийн иргэд, уул уурхайн компаниудын хоорондын харилцаа
16. Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдал
17. Нийгмээс уул уурхайд хандаж буй хандлага
18. Авлигаас ангид байдал
19. Туслан гүйцэтгэгчийн хүртээмжтэй байдал, чанар
20. Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломж

2019 онд хийгдсэн Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны судалгаанд санал өгсөн байгууллагуудын зүгээс Төрийн байгууллага болон уул уурхайн компаниудын хоорондын харилцаа, хандлагын талаар үнээлгээний асуулга оруулах хүсэлтүүд ирүүлсний дагуу энэ жилийн судалгаанд дээрх асуулт нэмэгдсэн.

Санал асуулгад оролцогч нь дээрх 20 үзүүлэлт тус бүрт өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж одоогийн байдлыг бодолцон үзэж дараах 5 хариултын аль нэгийг сонгож үнэлэлт өгөхөөр зохицуулсан.

1. Маш муу
2. Муу
3. Дунд зэрэг
4. Сайн
5. Маш сайн

Асуулгын хариултыг интернетийн орчинд, албан бичгээр, биечлэн шууд асуултыг бөглөх зэрэг олон төрлийн хэлбэрээр хүлээн авсан.

Судалгаанд уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 1800 гаруй байгууллагыг хамруулахыг зорьсон боловч цар тахлын улмаас хөл хорионд орсон, хаягийн бүртгэл буруу, цахим хаяг ашиглагдахгүй болсон, холбоо барих утас нь буруу зэрэг шалтгаанаас болж асуулга хүргэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй бөгөөд 130 байгууллага судалгаанд оролцож, асуулгад хариулт ирүүлжээ.

2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН


Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчинд 100 хүртэлх оноогоор үнэлэлт өгсөн. Судалгаанд оролцогчдоос ирүүлсэн хариултыг үнэлгээ тус бүрийн хувийн жинг гаргаж, жигнэсэн дундаж гаргах байдлаар тооцоолж нэгдсэн үнэлгээг тодорхойлсон.

Үнэлгээний 5 категори нь 100 онооны системд дараах онооны интервалтай байхаар тооцоолсон.

- маш муу үнэлгээ нь 34 хүртэл оноо,
- муу үнэлгээ нь 34-өөс 50 оноо,
- дунд үнэлгээ нь 50-иас 66 оноо,
- сайн үнэлгээ нь 66-гаас 84 оноо,
- маш сайн үнэлгээ нь 84-өөс дээш оноо

Энэ жилийн хувьд нэгдсэн дүнгээр Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин **56.9** оноо авч “Дунд зэрэг” гэсэн үнэлгээтэй гарсан байна. Судалгааны асуултуудаас маш сайн, маш муу үзүүлэлттэй асуулт гараагүй бөгөөд сайн ангилалд 1, дунд ангилалд 13 үзүүлэлт, муу ангилалд 6 үзүүлэлт хамрагдав. Энэ нь өнгөрсөн жилийн үнэлгээнээс ерөнхий үнэлгээ 3.4 нэгж хувиар өссөн бөгөөд муу ангилалд хамрагдсан асуулт 9 байснаас 6 болж буурч, дунд ангилалд орсон асуулт 10 байснаас 13 болж нэмэгдэж, шинээр сайн ангилалд 1 асуулт орж хөрөнгө оруулалтын орчин сайжирсан үзүүлэлттэй байна.

Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ



Хамгийн өндөр оноо авсан нь Туслан гүйцэтгэгчийн хүртээмжтэй байдал, чанар /70.3 оноо/ байсан бол Амьдрах орчны аюулгүй байдал /65.8 оноо/, Уул уурхайн татварын орчин /65.4 оноо/, Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал /64.2 оноо/, Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал /64.0 оноо/, Байгаль орчны хууль, дүрэм, журмын тодорхой байдал /63.1 оноо/ гэсэн асуултууд нь дунд үзүүлэлт дотроо дээгүүр эрэмбэлэгдлээ. Харин Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж /61.8 оноо/, Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж /60.3 оноо/, Уул уурхайн үйл ажиллагааны хууль, дүрмийн тодорхой байдал /60.0 оноо/, Төрийн байгууллагын харилцаа, хандлага /58.0 оноо/, Авлигаас ангид байдал /57.4 оноо/ үзүүлэлт нь дунд ангилалын дундуур жагсжээ. Дунд ангилалдаа доогуурт Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал /56.3 оноо/, Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломж /52.5 оноо/, Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдал /52.5 оноо/ зэрэг үзүүлэлтүүд жагсжээ.


Муу ангилалд орсон үзүүлэлтээс хамгийн тааруу дүн үзүүлсэн нь Нийгмээс уул уурхайд хандаж буй хандлага /42.9 оноо/ бол үүний дараа Улс төрийн тогтвортой байдал /43.1 оноо/ орсон. Дараагийн төвшний тааруухан үзүүлэлт нь Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөө /46.9 оноо/, Хөрөнгө оруулагчийн хууль, ёсны эрх ашгийг хамгаалсан байдал /48.9 оноо/ байхад Нутгийн иргэд, уул уурхайн компаниудын хоорондын харилцаа /51.2 оноо/, Дэд бүтцийн хөгжил /51.2 оноо/ байсан бол муу ангилал дотроо арай гайгүй үзүүлэлттэй байсан ба бараг дунд ангилалд хамрагдах дөхсөн.

3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1. ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЭЛ ХЯЛБАР ОЛЖ АВАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологийн мэдээлэл хялбар авах боломж дунджаас дээгүүр буюу 61.8% байна. Нийт судалгаанд оролцогсодын 54.6% нь дунд зэрэг, 24.6% нь сайн, 13.8% нь муу, 3.1% нь маш сайн, 3.8% нь маш муу гэж хариулсан байна. Өмнөх жилийн үзүүлэлтээс 0.2 нэгж хувиар нэмэгдсэн.

Зураг 6. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийн үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 101 аж ахуй нэгж цахимжуулж, онлайнаар үзэх, авах боломжтой болгох, 20 аж ахуй нэгж мэдээллийн сан, сайтын мэдээллийг шинэчлэх, сайжруулах, 10 аж ахуй нэгж нээлттэй, ил тод болгох, 10 аж ахуй нэгж түгээлтийн сувгийг өргөжүүлэх гэх мэт хариулт өгчээ.

Хүснэгт 1. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийг сайжруулах санал


Саналын багц	Тоо
Цахимжуулж, онлайнаар үзэх, авах боломжтой болгох	101
Мэдээллийн сан, сайтын мэдээллийг шинэчлэх, сайжруулах	20
Нээлттэй, ил тод болгох	10
Түгээлтийн сувгийг өргөжүүлэх	10
Боломжийн	5
Сургалт, сурталчилгаа	5
Төвлөрсөн цахим мэдээллийн сан, лавлах, утастай болох	5
Төлбөр үнэтэй	3
Хууль эрх зүйн орчныг сайжруулах	3

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 62.3%-ийг цахимжуулж, онлайн-аар үзэх, авах боломжтой болгох гэсэн санал эзэлж байна.

3.2. ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮНЭМШИЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологи, хайгуулын ажлын үнэмшил дунджаас дээгүүр буюу 64.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 54.6% нь дунд зэрэг, 31.5% нь сайн, 10.8% нь муу, 10.8% нь маш муу, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна. Өмнөх жилийн үзүүлэлтээс 0.3 нэгж хувиар буурсан.

Зураг 7. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 37 аж ахуй нэгж хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх, 30 аж ахуй нэгж мэргэжлийн хүнээр чанартай, нарийвчилж гүйцэтгэх, 14 аж ахуй нэгж мэргэжлийн байгууллагыг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, 9 аж ахуй нэгж сургалт, гарын авлага, стандарт бий болгох, 9 аж ахуй нэгж ил тод, цахим болгох гэсэн хариулт өгчээ.

Хүснэгт 2. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлыг сайжруулах санал


Саналын багц	Тоо
Хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх	37
Мэргэжлийн хүнээр чанартай, нарийвчилж гүйцэтгэх	30
Мэргэжлийн байгууллагыг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх	14
Сургалт, гарын авлага, стандарт бий болгох	9
Ил тод, цахим болгох	8

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 37.8%-ийг хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх гэсэн санал эзэлж байна.

3.3. УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ дунджаас доогуур буюу 43.1% байна. Нийт судалгаанд оролцогсодын 32.3% нь маш муу, 32.3% нь муу, 23.1% нь дунд зэрэг, 12.3% нь сайн гэж хариулсан бол маш сайн үнэлгээ өгөөгүй байна. Өмнөх жилийн үзүүлэлтээс 5.7 нэгж хувиар өсөхөд маш муу үнэлгээний хувийн жин 7, муу үнэлгээний хувийн жин 4.9 нэгж хувиар багасаж сайн үнэлгээний хувийн жин 10.3 нэгж хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн.

Зураг 8. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 48 аж ахуй нэгж бодлого, хууль эрх зүйн орчин тогтвортой байх, 24 аж ахуй нэгж салбарыг улс төр, намаас ангид байлгах, хамаарлыг багасгах, 18 аж ахуй нэгж тогтолцоог өөрчлөх, 17 аж ахуй нэгж бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах, 14 аж ахуй нэгж ЗГ, Төрийн байгууллага тогтвортой байх гэх зэргээр хариулжээ.

Хүснэгт 3. Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал

Саналын багц	Тоо
Бодлого, хууль эрх зүйн орчин тогтвортой байх	48
Салбарыг улс төр, намаас ангид байлгах, хамаарлыг багасгах	24
Тогтолцоог өөрчлөх	18
Бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах	17
ЗГ, Төрийн байгууллага тогтвортой байх	14
Хууль хэрэгжүүлэх	9
Улс төрчдийн хариуцлагыг сайжруулах	8
Иргэд, хөдөлгөөнийг зохицуулах, нийгмийн идэвхтэй байх	8
Мэргэшсэн мэргэжилтнүүд тогтвортой байх	5


Удирдах өндөр албан тушаалд мэргэжлийн хүнийг томилуулах	5
Авлигаас ангид байлгах	4

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 30%-ийг бодлого, хууль эрх зүйн орчин тогтвортой байх гэсэн санал эзэлж байна.

3.4. УУЛ УУРХАЙН ХУУЛЬ, ДҮРМИЙН ТОДОРХОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 60.0% байна. Нийт судалгаанд оролцогсодын 46.9% нь дунд зэрэг, 26.2% нь сайн, 18.5% нь муу, 6.2% нь маш муу, 2.3% нь маш сайн гэж хариулсан байна. Өмнөх жилийн үзүүлэлтээс 4.2 нэгж хувиар өсөхөд муу үнэлгээний хувийн жин 6.4 нэгж хувиар багасаж сайн үнэлгээний хувийн жин 9 нэгж хувиар нэмэгдсэн голлох нөлөөг үзүүлсэн.

Зураг 9. Уул уурхайн хууль дүрмийн тодорхой байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 23 аж ахуй нэгж хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах, 20 аж ахуй нэгж тодорхой, ойлгомжтой болгох, 18 аж ахуй нэгж сурталчлан таниулах, 17 аж ахуй нэгж тогтвортой байлгах, 16 аж ахуй нэгж сайжруулах гэх зэргээр хариулжээ.

Хүснэгт 4. Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлыг сайжруулах санал

Саналын багц	Тоо
Хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах	23
Тодорхой, ойлгомжтой болгох	20
Сурталчлан таниулах	18
Тогтвортой байлгах	17
Сайжруулах	16
Сайн хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах	11


Багасгах, цөөлөх, хялбаршуулах	10
Мэргэжлийн судалгаа, хүмүүсийн саналыг авах	9
Орон нутгийн эрх мэдлийг багасгах, орон нутгийн захирамж хуулиас илүү гардаг	8
Хууль эрх зүйн орчин дутмаг	7
Боломжийн байна	6
Цэгцлэх	6
Бодит байдалтай уялдуулах	3
Олон улсын жишиг судлах	2

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 14.7%-ийг хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах гэсэн санал эзэлж байна.

3.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ДҮРМИЙН ТОДОРХОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд байгаль орчны хууль, дүрмийн тодорхой байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 63.1% байна. Нийт судалгаанд оролцогсодын 41.5% нь дунд зэрэг, 35.4% нь сайн, 13.8% нь муу, 6.2% нь маш муу, 3.1% нь маш сайн гэж хариулсан байна. Өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 5.2 нэгж хувиар нэмэгдэхэд муу үнэлгээний хувийн жин 4.6 нэгж хувь, дунд зэрэг үнэлгээний хувийн жин 9.3 нэгж хувиар буурч, сайн үнэлгээний хувийн жин 15 нэгж хувиар өссөнтэй холбоотой.

Зураг 10. Байгаль орчны хууль дүрмийн тодорхой байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 22 аж ахуй нэгж хууль хоорондын болон дүрэм, журмыг уялдаатай болгох, 21 аж ахуй нэгж хууль тогтоомжийг сурталчлах, 17 аж ахуй нэгж хууль эрх зүйн орчинг сайжруулах, 17 аж ахуй нэгж тодорхой болгох, 14 аж ахуй нэгж хуулиа хэрэгжүүлдэг, хариуцлагатай байх гэх зэргээр хариулжээ.

Хүснэгт 5. Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлыг сайжруулах санал


Саналын багц	Тоо
Хууль хоорондын болон дүрэм, журмыг уялдаатай болгох	22
Хууль тогтоомжийг суртачилах	21
Хууль эрх зүйн орчинг сайжруулах	17
Тодорхой болгох	17
Хуулиа хэрэгжүүлдэг, хариуцлагатай байх	14
Нөхөн сэргээлтэд анхаарах	8
Ашиглалт, хайгуулыг ялгаж дүрэм журмыг өөрчлөх	6
Хувиараа АМОлборлогчдод зориулсан эрх зүйн орчин шаардлагатай	4
Нэг талыг хэт барьсан хууль, дүрэм, журам гаргадаг	3
Боломжийн	3

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 19.1%-ийг хууль хоорондын болон дүрэм, журмыг уялдаатай болгох гэсэн санал эзэлж байна.

3.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛСАН БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдлын үнэлгээ дунджаас доогуур буюу 48.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 35.4% нь дунд зэрэг, 33.8% нь муу, 17.7% нь маш муу, 12.3% нь сайн, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна. Өмнөх жилийн үзүүлэлтээс 1.6 нэгж хувиар ахисан.

Зураг 11. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 40 аж ахуй нэгж тодорхой, тогтвортой байх, 35 аж ахуй нэгж хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах хууль тогтоомжийг суртачилах, 30 аж ахуй нэгж хуульд өөрчлөлт оруулах гэх мэтчилэн хариулжээ.

Хүснэгт 6. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан байдлыг сайжруулах санал


Саналын багц	Тоо
Тодорхой, тогтвортой байх	40
Хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах	35
Хуульд өөрчлөлт оруулах, сайжруулах	30
Мэдээлэл суртачилгаа хийх	8
Орон нутгийн удирдлагатай зөрчилтэй	5
Төрийн байгууллагын хүнд суртал	5

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 32.5%-ийг тодорхой, тогтвортой байх гэсэн санал эзэлж байна.

3.7. УУЛ УУРХАЙН ТАТВАРЫН ОРЧИН

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн татварын орчны үнэлгээ дунджаас дээгүүр буюу 65.4% байна. Нийт судалгаанд оролцогсодын 43.1% нь дунд зэрэг, 33.1% нь сайн, 8.5% нь маш сайн, 7.7% нь муу, 7.7% нь маш муу гэж хариулсан байна. Өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 7.1 нэгж хувиар өсөхөд муу үнэлгээний хувийн жин 10.9 нэгж хувь, дунд үнэлгээний хувийн жин 8.1 нэгж хувиар багасаж, сайн үнэлгээний хувийн жин 12 нэгж хувь, маш сайн үнэлгээний хувийн жин 6.7 нэгж хувиар нэмэгдснээс шалтгаалсан.

Зураг 12. Уул уурхайн татварын орчин



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 18 аж ахуй нэгж татварыг орчныг тогтвортой байлгах, 18 аж ахуй нэгж АМНАТ-ыг бууруулах, 11 аж ахуй нэгж давхардуулж авахгүй байх, 11 аж ахуй нэгж ойлгомжтой болгох, 10 аж ахуй нэгж хэрэгжилтийг сайжруулж, мэдээлэл сурталчилгаа хийх гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 7. Уул уурхайн татварын орчныг сайжруулах санал

Саналын багц	Тоо
Татварыг орчныг тогтвортой байлгах	18
АМНАТ-ыг бууруулах	18
Давхардуулж авахгүй байх	11
Ойлгомжтой болгох	11
Хэрэгжилтийг сайжруулж, мэдээлэл сурталчилгаа хийх	10
Хууль эрх зүйн орчинг сайжруулах	9
Эрх шилжүүлсний татвар бууруулах	8
Уян хатан татварын системтэй болох	7
Бусад татварыг багасгах, Хөнгөлөлт олгох	5
Татварын орлогын хуваарилалтыг өөрчлөх	5
Харьяаллыг орон нутагт шилжүүлэх	3


Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 17.1%-ийг татварыг орчныг тогтвортой байлгах, мөн 17.1%-ийг АМНАТ-ыг бууруулах гэсэн санал эзэлж байна.

3.8. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд дэд бүтцийн хөгжлийн үнэлгээ дунджаас доогуур буюу 51.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 36.2% нь муу, 33.8% нь дунд зэрэг, 15.4% нь сайн, 13.1% нь

маш муу, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна. Өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 1.7 нэгж хувиар өсжээ.

Зураг 13. Дэд бүтцийн хөгжил



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 27 аж ахуй нэгж төмөр зам барих, 16 аж ахуй нэгж төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, 14 аж ахуй нэгж төрийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөгөөр хөгжүүлэх, 14 аж ахуй нэгж авто зам барих, засвар үйлчилгээг сайжруулах, 14 аж ахуй нэгж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 8. Дэд бүтцийг хөгжүүлэх санал


Саналын багц	Тоо
Төмөр зам барих	27
Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа	16
Төрийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөгөөр хөгжүүлэх	14
Авто зам барих, засвар үйлчилгээг сайжруулах	14
Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	14
Дэд бүтцийн орчныг сайжруулах	12
Зохицуулалтыг сайжруулах	11
Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх	10
Хот томруулах, АҮПарк барих, Хилийн боомт нэмэх	7
Вагоны тоо, ТЗ-н нэвтрүүлэх чадварыг нэмэх	5
Сайн байгаа	3

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 20.3%-ийг төмөр зам барих гэсэн санал эзэлж байна.

3.9. МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮРЭЛЦЭЭТЭЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 62.4% байна. Нийт судалгаанд оролцогсодын 41.5% нь сайн, 36.2% нь дунд зэрэг, 16.9% нь муу, 3.8% нь маш муу, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс 1.6 нэгж хувиар нэмэгдсэн.

Зураг 14. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 47 аж ахуй нэгж мэргэжлийн сургалт зохион байгуулах, 11 аж ахуй нэгж оюутны дадлагыг илүү үр дүнтэй болгох, 10 аж ахуй нэгж ажлын байр нэмэгдүүлэх,, 7 аж ахуй нэгж боловсон хүчинг сайн бэлдэх, 4 аж ахуй нэгж ажиллах хүчийг тогтворжуулах гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 9. Мэргэжлийн ажиллах хүчийг нэмэгдүүлэх санал


Саналын багц	Тоо
Мэргэжлийн сургалт зохион байгуулах	47
Оюутны дадлагыг илүү үр дүнтэй болгох	11
Ажлын байр нэмэгдүүлэх	10
Боловсон хүчинг сайн бэлдэх	7
Ажиллах хүчийг тогтворжуулах	4
Хөдөлмөрийн үнэлэмжийг тодорхой болгох	3
Ажиллах таатай орчинг бий болгох	2
Хөдөлмөрийн хууль зөрчигддөг	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 55.3%-ийг мэргэжлийн сургалт зохион байгуулах гэсэн санал эзэлж байна.

3.10. АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд амьдрах орчны аюулгүй байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 65.8% байна. Нийт судалгаанд оролцогсодын 54.6% нь дунд зэрэг, 30.8% нь сайн, 9.2% нь муу, 4.6% нь маш сайн, 0.8% нь маш муу гэж хариулсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс 6.2 нэгж хувиар нэмэгдэхэд муу үнэлгээний хувийн жин 8 нэгж хувь, маш муу үнэлгээний хувийн жин 4.7 нэгж хувиар буурч, сайн үнэлгээний хувийн жин 7.1 нэгж хувь, маш сайн үнэлгээний хувийн жин 3.2 нэгж хувиар өссөнтэй холбоотой.

Зураг 15. Амьдрах орчны аюулгүй байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 21 аж ахуй нэгж аюулгүй ажилгааны хууль дүрмийг баримтлан ажиллах, 12 аж ахуй нэгж ААН-ийн хариуцлагаас шалтгаална, 6 аж ахуй нэгж стандартаа тодорхой болгох, мөрдүүлэх, 5 аж ахуй нэгж орчин үеийн технологийг нутагшуулах, 4 аж ахуй нэгж төвлөрлийг тараах нь амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулна гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 10. Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал

Саналын багц	Тоо
Аюулгүй ажилгааны хууль дүрмийг баримтлан ажиллах	21
ААН-ийн хариуцлагаас шалтгаална	12
Стандартаа тодорхой болгох, мөрдүүлэх	6
Орчин үеийн технологийг нутагшуулах	5
Төвлөрлийг тараах нь амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулна	5
Дэд бүтэцийг сайжруулах	3
Стандарт зөрчигдөхөд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх	3
Сургалт зохион байгуулах	3
ТББ-ыг цэгцлэх	3
Гадны хөрөнгө оруулалтай компани монгол ажилчдын амьдрах орчин хангалтгүй байдаг	1


Нөхөн сэргээлт хийх	1
Нэгдсэн бодлоготой болгох	1
Орон нутагтай хийх хамтын ажиллагааны гэрээнд нарийвлан тусгаж өгөх	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 32.3%-ийг аюулгүй ажилгааны хууль дүрмийг баримтлан ажиллах гэсэн санал эзэлж байна.

3.11. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд газрын харилцааны зохицуулалтын байдал дунджаас доогуур буюу 56.3% байна. Нийт судалгаанд оролцогсодын 45.4% нь дунд зэрэг, 22.3% нь муу, 20.8% нь сайн, 10% нь маш муу, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна. Өнгөрсөн оны үзүүлэлтээс 2.1 нэгж хувиар өссөн.

Зураг 16. Газрын харилцааны зохицуулалтын байдал



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 15 аж ахуй нэгж орон нутгийн оролцоог багасгах, 14 аж ахуй нэгж газрын тухай хуулийг сайжруулах мөн ард иргэдэд суртачилж таниулах, 13 аж ахуй нэгж газрын харилцааны байгууллагуудыг нэгдсэн системтэй болгох, 10 аж ахуй нэгж газрын төлбөрийн гэнэтийн өсөлт мөн давхар төлбөр төлөхийг зогсоох, 8 аж ахуй нэгж бодлогоор дэмжих, мэдээлэл олон нийтэд нээлттэй байх гэх мэтээр хариулжээ..

Хүснэгт 11. Газрын харилцааны зохицуулалтыг сайжруулах санал

Саналын багц	Тоо
Орон нутгийн оролцоог багасгах	15
Газрын тухай хуулийг сайжруулах мөн ард иргэдэд суртачилж таниулах	14


Газрын харилцааны байгууллагуудыг нэгдсэн системтэй болгох	13
Газрын төлбөрийн гэнэтийн өсөлт мөн давхар төлбөр төлөхийг зогсоох	10
Бодлогоор дэмжих, мэдээлэл олон нийтэд нээлттэй байх	8
Төлөвлөлт зохион байгуулалтыг сайн хийх	5
Хүнд суртлыг арилгах	5
Газрын үнэлгээ аймаг бүрт өөр өөр байгааг хуулийн орчинд засах	4
Давхардсан олон зөвшөөрөл авдаг байдлыг болих шаардлагатай	2
Байгууллага хоорондын уяалдааг сайжруулах	1
Газар олголтыг нэг цэгт төвлөрүүлэх	1
Газрын мэдээллийг нээлттэй болгох	1
Газрын үнэлгээ аймаг бүрт өөр өөр байгааг хуулийн орчинд засах	1
Газрын хуулийг бодитой болгох	1
Мэргэжлийн боловсон хүчин дутмаг	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 18.3%-ийг орон нутгийн оролцоог багасгах гэсэн санал эзэлж байна.

3.12. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ дунджаас доогуур буюу 46.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 35.4% нь дунд зэрэг, 33.8% нь муу, 20.8% нь маш муу, 10% нь сайн гэж хариулсан бол маш сайн хариултыг илгээгүй байна. Өмнөх оны үзүүлэлтээс 1 нэгж хувиар ахисан.

Зураг 17. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 55 аж ахуй нэгж бодлого тогтвортой байх, 8 аж ахуй нэгж ААН-ийг дэмжсэн бодлого баримтлах, 7 аж ахуй нэгж хуулийн орчинг тогтвортой болгох, 6 аж ахуй нэгж эрх ашгийг хамгаалах, 4 аж ахуй нэгж татварын бодлогоор дэмжих гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 12. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөг сайжруулах санал

Саналын багц	Тоо
Бодлого тогтвортой байх	55
ААН-ийг дэмжсэн бодлого баримтлах	8
Хуулийн орчинг тогтвортой болгох	7
Эрх ашгийг хамгаалах	6
Татварын бодлогоор дэмжих	4
Засгийн газрын буруу бодлого мөн тогтворгүй байдал	2
Орон нутгийн эрх мэдлийг хязгаарлах	2
Төр хэт их оролцохгүй байх	2
Хууль эрх зүйн орчинг сайжруулах	2
Ажиллах хүчинд нээлттэй бодлого явуулах	1
Аймаг сумын мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх	1
Банкны хүү хэт өндөр	1
Бодлогоор дэмжих	1
Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг дахин хэлэлцэх	1
Мэдээлэл хомс	1
Нэгдсэн нэг тогтвортой хуультай болох	1
ТББ-уудын хуулийн орчинг цэгцлэх	1
Төрийн албан хаагчид ажил үүргээ цаг тухайд нь хийдэг болох	1
Төрийн оролцоог хязгаарлах	1
Тусгай зөвшөөрлийг цуцлахаар бол нөхөн олговор олгох	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 55.6%-ийг бодлого тогтвортой байх гэсэн санал эзэлж байна.

3.13. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАА, ХАНДЛАГА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд төрийн байгууллагын харилцаа, хандлагын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 60.3% байна. Нийт судалгаанд оролцогсодын 36.9% нь сайн, 30.8% нь дунд зэрэг, 16.9% нь маш муу, 10.8% нь муу, 4.6% нь маш сайн гэж хариулсан байна. Энэ үзүүлэлт өнгөрсөн жилийн судалгаанд оролцогсодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу шинээр нэмэгдсэн.

Зураг 18. Төрийн байгууллагын харилцаа, хандлагын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 55 аж ахуй нэгж бодлого тогтвортой байх, 8 аж ахуй нэгж ААН-ийг дэмжсэн бодлого баримтлах, 7 аж ахуй нэгж хуулийн орчинг тогтвортой болгох, 6 аж ахуй нэгж эрх ашгийг хамгаалах, 4 аж ахуй нэгж татварын бодлогоор дэмжих гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 13. Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөг сайжруулах санал


Саналын багц	Тоо
Бодлого тогтвортой байх	55
ААН-ийг дэмжсэн бодлого баримтлах	8
Хуулийн орчинг тогтвортой болгох	7
Эрх ашгийг хамгаалах	6
Татварын бодлогоор дэмжих	4
Засгийн газрын буруу бодлого мөн тогтворгүй байдал	2
Орон нутгийн эрх мэдлийг хязгаарлах	2
Төр хэт их оролцохгүй байх	2
Хууль эрх зүйн орчинг сайжруулах	2
Ажиллах хүчинд нээлттэй бодлого явуулах	1
Аймаг сумын мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх	1
Банкны хүү хэт өндөр	1
Бодлогоор дэмжих	1
Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг дахин хэлэлцэх	1
Мэдээлэл хомс	1
Нэгдсэн нэг тогтвортой хуультай болох	1
ТББ-уудын хуулийн орчинг цэгцлэх	1
Төрийн албан хаагчид ажил үүргээ цаг тухайд нь хийдэг болох	1
Төрийн оролцоог хязгаарлах	1
Тусгай зөвшөөрлийг цуцлахаар бол нөхөн олговор олгох	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 55.6%-ийг бодлого тогтвортой байх гэсэн санал эзэлж байна.

3.14. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ дунджаас дээгүүр буюу 54.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 34.8% нь дунд зэрэг, 23.9% нь муу, 21.5% нь сайн, 15.6% нь маш муу, 4.2% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 19. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 33 аж ахуй нэгж мэдээ мэдээллийг сурталчилж таниулах, 23 аж ахуй нэгж орон нутагт хамаагүй эрх мэдлийг олгохгүй байх, 23 аж ахуй нэгж хамтарч ажиллах, 11 аж ахуй нэгж хуулиа дагаж мөрдөх мөн сайжруулах, 9 аж ахуй нэгж авилгын асуудал гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 14. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал

Саналын багц	Тоо
Мэдээ мэдээллийг сурталчилж таниулах	33
Орон нутагт хамаагүй эрх мэдлийг олгохгүй байх	23
Хамтарч ажиллах	23
Хуулиа дагаж мөрдөх мөн сайжруулах	11
Авилгын асуудал	9


АМНАТ-ын тодорхой хувийг орон нутагт үлдээдэг байх	4
Тогтвортой байх	4
Ил тод байдал	3
Орон нутгаас ирэх дарамтыг багасгах	3
Орон нутгийн удирдлага болон Яамнууд байгууллагуудын уяалдаа маш муу	3
Тодорхой болгох	2
Хуулиа дагаж мөрдөх	2
Улс төрийн нөлөөнөөс ангид байлгах	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 27.3%-ийг мэдээ мэдээллийг суртачилж таниулах гэсэн санал эзэлж байна.

3.15. НУТГИЙН ИРГЭД УУЛ УУРХАЙН КОМПАНИ ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааны үнэлгээ дунджаас доогуур буюу 48.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 33.6% нь дунд зэрэг, 27.9% нь муу, 22.7% нь маш муу, 14% нь сайн, 1.8% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 20. Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааны үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 70 аж ахуй нэгж уул уурхайн салбарыг таниулах, суртачилах, ойлгуулах, 22 аж ахуй нэгж нэгдсэн бодлоготой болох, 10 аж ахуй нэгж хууль нэг бүлэг болгож нэрлэх, 7 аж ахуй нэгж иргэдтэй нээлттэй харилцах хамтарч ажиллах гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 15. Нутгийн иргэд уул уурхайн компани хоорондын харилцааг сайжруулах санал

Саналын багц	Тоо
Уул уурхайн салбарыг таниулах, суртачилах, ойлгуулах	70
Нэгдсэн бодлоготой болох	22


Хууль нэг бүлэг болгож нэрлэх	10
Иргэдтэй нээлттэй харилцах хамтарч ажиллах	7
Иргэд хуулиа дагаж мөрдөж ухамсарлах, хуулийн мэдлэг олгох	4
Нутгийн иргэдээс ажилд авах	4
Хамтарч ажиллах	4
Зохион байгуулалттай хөдөлгөөнтэй хамтарч ажиллахад бэрхшээлтэй	2
Нутгийн гол мөрөн, нуур цөөрмийг хамгаалж бохирдуулахгүй байх	2
Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хэрэгтэй	2
Мэдээлэл муу байгаагаас худал явган ярианд хэт итгэдэг	1
Орон нутгийн эрх мэдлийг багасгах хэрэгтэй	1
Улс төржүүлэхгүй байх	1
Халамжийн бодлогыг хяналттай явуулах	1
Хариуцлагатай байхыг шаардах	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 53%-ийг уул уурхайн салбарыг таниулах, суртачилах, ойлгуулах гэсэн санал эзэлж байна.

3.16. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД ХЯЛБАР БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ дундаж буюу 50.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 43.1% нь дунд зэрэг, 29.1% нь муу, 16.2% нь маш муу, 10.9% нь сайн, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 21. Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 17 аж ахуй нэгж цахим болгох, 12 аж ахуй нэгж орон нутгийн иргэдийн оролцоог багасгах, 10 аж ахуй нэгж ил тод тогтвортой байх, 10 аж ахуй нэгж хэт олон давхардсан шат дамжлагыг зохицуулах гэх зэргээр хариулсан байна.

Хүснэгт 16. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах ажиллагааг хялбаршуулах санал


Саналын багц	Тоо
Цахим болгох	17
Орон нутгийн иргэдийн оролцоог багасгах	12
Ил тод тогтвортой байх	10
Хэт олон давхардсан шат дамжлагыг зохицуулах	10
Өргөдлөөр хайгуулийн тусгай зөвшөөрөл олгох	6
Хууль эрх зүйн орчинг сайжруулах	6
Хүнд суртал, ашиг сонирхолын зөрчил	6
Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	5
Тусгай зөвшөөрлийн асуудлууд	5
Үйлчилгээг хуулийн хугацаанд хурдан шийдвэрлэх	5
Сонгоны асуудал	3
Нэгдсэн мэдээлэл ажлын уялдаагаа сайжруулах	2
Эцсийн шийдвэрийг орон нутаг гаргадаг болгох	2

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 17.3%-ийг цахим болгох гэсэн санал эзэлж байна.

3.17. НИЙГМЭЭС УУЛ УУРХАЙД ХАНДАХ ХАНДЛАГА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас нийгмээс уул уурхайд хандах хандлагын үнэлгээ дунджаас доогуур буюу 41.7% байна. Нийт судалгаанд оролцогсодын 34.6% нь муу, 31.4% нь маш муу, 28.7% нь дунд зэрэг, 4.9% нь сайн, 0.4% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 22. Нийгмээс уул уурхайд хандах хандлагын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 40 аж ахуй нэгж нийтэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх, 23 аж ахуй нэгж

сурталчилах үйл ажиллагааг тогмол явуулах, 14 аж ахуй нэгж улс төрчид болон ТББ-ууд үнэн зөв мэдээллийг ард иргэдэд зөв мэдээ мэдээлэл тараах, 9 аж ахуй нэгж хуулиар тодорхой нэгдсэн бодлоготой болох гэх мэтээр хариулжээ..

Хүснэгт 17. Нийгмээс уул уурхайд хандах хандлагыг сайжруулах санал


Саналын багц	Тоо
Нийгэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх	40
Сурталчилах үйл ажиллагааг тогмол явуулах	23
Улс төрчид болон ТББ-ууд үнэн зөв мэдээллийг ард иргэдэд зөв мэдээ мэдээлэл тараах	14
Хуулиар тодорхой нэгдсэн бодлоготой болох	9
Популизмыг багасгах	6
Нийгмийн хандлагыг өөрчлөх	5
Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх	5
Хууль бус олборлолтыг зогсоох	5
Сошиалаар мэдээ мэдээллийг сайн ойлгуулах	4
Нөхөн сэргээлтийн ажлыг сайжруулах	3

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 34.5%-ийг нийгэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх гэсэн санал эзэлж байна.

3.18. АВЛИГААС АНГИД БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас авлигаас ангид байдлын үнэлгээ дундаж буюу 50.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 41.7% нь дунд зэрэг, 25.7% нь муу, 18% нь маш муу, 13% нь сайн, 1.6% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 23. Авлигаас ангид байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 11 аж ахуй нэгж нээлттэй ил тод болгох, 8 аж ахуй нэгж хуулийн дагуу ажиллах хэрэгтэй, 8 аж ахуй нэгж цахим болгох, 6 аж ахуй нэгж орон нутгийн оролцоог багасгах, 6 аж ахуй төрийн албаны хүнд суртлын системийг бүрэн устгах гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 18. Авлигаас ангид байлгах санал


Саналын багц	Тоо
Нээлттэй ил тод болгох	11
Хуулийн дагуу ажиллах хэрэгтэй	8
Цахим болгох	8
Орон нутгийн оролцоог багасгах.	6
Төрийн албаны хүнд суртлын системийг бүрэн устгах	6
Заасан хугацаандаа шийдвэрээ гаргах, болохгүй байгаа зүйлийг зөвлөдөг байх	5
Хууль эрх зүйн орчинг сайжруулах	5
Авилга авсан албан хаагчид ногдуулах арга хэмжээг чангатгах	4
Хүнд сурталгүй ажиллах	4
Хэт олон шат дамжлагатай	4
Мэдээлэл нээлттэй болгох	3
Орон нутгийн оролцоог багасгах	3
Шударга байх	3
Авилгал өгөхгүй бол шат бүрдээ хүнд суртал гардаг	2

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 12.6%-ийг нээлттэй ил тод болгох гэсэн санал эзэлж байна.

3.19. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮРЭЛЦЭЭ, ЧАНАР

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 64.4% байна. Нийт судалгаанд оролцогсодын 52% нь дунд зэрэг, 29.4% нь сайн, 10.9% нь муу, 4.7% нь сайн, 3% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 24. Туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 14 аж ахуй нэгж ААН-с өөрөөс нь хамаарна, 6 аж ахуй нэгж гэрээгээ чанартай биелүүлэх, 5 аж ахуй нэгж олон улсын стандартад хүргэх, 5 аж ахуй нэгж уялдаа холбоог сайжруулах гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 19. Туслан гүйцэтгэгчийн чадавхийг нэмэгдүүлэх санал

Саналын багц	Тоо
ААН-с өөрөөс нь хамаарна	14
Гэрээгээ чанартай биелүүлэх	6
Олон улсын стандартад хүргэх	5
Уялдаа холбоог сайжруулах	5
ААН-үүдийн ур чадварыг нэмэгдүүлэх	3
Хууль эрх зүйн орчинг сайжруулах	3
Ажиллах таатай орчинг бүрдүүлэх	2
Олон байгууллага байхгүй	2
Татварын тодорхой дэмжлэгэ үзүүлдэг байх	2
Хөрөнгө оруулагчыг дэмжих	2
гэрээндээ нарийн тусгаж ажиллах	1
Дотоодын компаний чадавхыг нэмэгдүүлэх мөн үйлчилгээний соёлыг нэмэгдүүлэх	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 26.4%-ийг ААН-с өөрөөс нь хамаарна гэсэн санал эзэлж байна.

3.20. ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, ХУВЬЦАА ЭЗЭМШИХ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ дундаж буюу 50.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 38.3% нь дунд зэрэг, 33.2% нь муу, 14% нь маш муу, 13.2.8% нь сайн, 1.6% нь маш сайн гэж хариулсан байна.

Зураг 25. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ



Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 38 аж ахуй нэгж мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжтой болгох, 12 аж ахуй нэгж нээлттэй ил тод байх, 8 аж ахуй нэгж бодлого тогтвортой байх, 7 аж ахуй нэгж хөрөнгийн биржийн үйл ажиллагааг ил тод болгох, 5 аж ахуй нэгж мэдээллийг бусдад түгээх гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 20.. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх санал

Саналын багц	Тоо
Мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжтой болгох	38
Нээлттэй ил тод байх	12
Бодлого тогтвортой байх	8
Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг ил тод болгох.	7
Мэдээллийг бусдад түгээх	5
Хууль эрх зүйн орчинг сайжруулах	5
Мэдээлэл хангалтгүй байдаг	4
Сургалт суртачилгааг нэмэгдүүлэх	3
Итгэл үнэмшлийг баталгаажуулах	2
Гадаад зах зээлд нээлттэй бодлого барих	1
Иргэдийн боловсрол муу	1
Лавлах утастай болох	1

Мөн түүнчлэн сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 40.4%-ийг мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжтой болгох гэсэн санал эзэлж байна.

4. ДҮГНЭЛТ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны 2019 оны байдлыг судалж үзээд дараах дүгнэлтэд хүрлээ.

- Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ **53.5** оноо буюу “**ДУНД**” гэсэн үнэлгээтэй байна.
- Үнэлгээг нэгтгэн гаргасан 19 үзүүлэлтээс “маш сайн”, “сайн” гэсэн үнэлгээ гараагүй байгаа нь хөрөнгө оруулалтын орчин таатай гэж үзэх боломжгүй байна. Мөн “маш муу” гэсэн үзүүлэлт илрээгүй нөхцөл байдал хэт хүндрээгүй байгааг илтгэж байна.
- Хамгийн муу үзүүлэлт нь “Улс төрийн тогтвортой байдал” болсон шалтгаан нь сүүлийн жилүүдэд улс төрийн гэнэтийн шийдвэрүүд гарч, төрийн үйл ажиллагаа тогтвортой явахгүй, залгамж чанараа алдаж, төр засаг солигдох болгонд шинэ бодлого, хууль эрх зүйн орчин бий болж, урт хугацааны төлөвлөгөөтэй бодлого байхгүй, салбарыг мэргэжлийн бус хүн удирдаж, төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа болон сонгууль дөхсөнтэй холбоотой улс төржилт нэмэгдсэнээс болсон.
- Дараагийн тааруухан үзүүлэлтэд “Нийгмээс уул уурхайн салбарт хандаж буй хандлага” орж байгаа нь ард иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл очихгүй, улс төрч, төрийн бус байгууллага худлаа, буруу мэдээлэл түгээж, популизм хийж байгаагийн зэрэгцээ хууль бус олборлолт, нөхөн сэргээлт хийдэггүй, хариуцлагатай уул уурхайг хангалттай хэмжээнд хөгжүүлэхгүй байгаатай холбоотой.
- Удаах муу үзүүлэлтийг жагсаалтад “Хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөө”, “Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал”, “Орон нутгийн иргэд болон уул уурхайн компанийн хоорондын харилцаа” ороход бодлого тогтвортой биш, хөрөнгө оруулагчийг хамгаалж, дэмждэггүй, төрийн байгууллагын хүнд суртал, мэдээлэл, сурталчилгаа, хамтын ажиллагаа муу зэрэг шалтгаан нөлөөлжээ.
- Муу ангилал дотроо гайгүй үзүүлэлтэд “Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломж” ороход мэдээлэл хангалтгүй, “Авлигаас ангид байдал”-д хүнд суртал ихтэй, “Тусгай зөвшөөрөл авахад хялбар байдал” ороход олон шат дамжлагатай, “Дэд бүтцийн хөгжил” сул байгаад төмөр зам, вагон дутагдалтай, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэхгүй, автозам барилт, түүний засвар үйлчилгээ тааруу байгаа зэрэг голлох шалтгаанууд нөлөөлсөн байна.
- Дунд ангиллын доогуур жагсаж байгаа үзүүлэлтэд газрын мэдээллийн нэгдсэн системгүй, орон нутгийн оролцоо ихтэй, мэдээлэл сурталчилгаа муутай байдлаар “Газрын харилцааны зохицуулалт”, орон нутгийн удирдлага хэт их эрх мэдэлтэй, мэдээлэл дутмаг, хууль сахидаггүй, авилгын асуудалтай байдлаар “Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж”, хуулиуд хоорондын болон дүрэм, журмын уялдаа холбоо муу, мэдээлэл, сурталчилгаа тааруу, тодорхойгүй байдал

ихтэй зэргээс шалтгаалж “Уул уурхайн үйл ажиллагааны болон Байгаль орчны хууль, дүрэм журмын тодорхой байдал” гэсэн үзүүлэлтүүд багтлаа.

- Татварын орчин тогтворгүй, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр өндөр зэрэг нь “Уул уурхайн татварын орчин”-г, Аюулгүй ажиллагааны хууль, дүрмийг баримталдаггүй, стандарт тодорхойгүй шалтгаан нь “Амьдрах орчны аюулгүй байдал”-ыг дунд ангилалд оруулсан.
- “Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж” нь мэдээлэл нь цахимжиж онлайн болоогүй, “Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал” нь ажиллах хүчийг чанартай бэлтгэх тал дээр тааруу байгаа, “Туслан гүйцэтгэгчийн хүртээмж, чанар” нь гэрээний үүргээ чанартай биелүүлэх хэрэгтэй болсноор, “Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал” нь хяналт, баталгаажуулалт тааруу, мэргэжлийн хүнээр чанартай хийлгэхгүйг байгаагаас болж дунд үзүүлэлтийн боломжийн төвшинд эрэмбэлэгджээ.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин 2019 оны байдлаар “Дунд” үнэлгээтэй болон үнэлгээний бүрэлдэхүүн үзүүлэлтүүд нь “маш сайн”, “сайн” үнэлгээнд хүрээгүй байгаа тул хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах шаардлагатай бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

- Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулахын тулд төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгаж, сайжруулж, урт хугацааны хөгжлийн бодлого гарган, түүнийгээ хайзахгүй хэрэгжүүлэх механизмийг бий болгох шаардлагатай. Салбарын үйл ажиллагааг нам, улс төрийн үйл ажиллагаанаас хамаарал багатай байлгахыг хичээж, Засгийн газар, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой явуулахад анхаарч, төрийн албан хаагчдыг өөрчилдөггүй болгож, удирдах өндөр албан тушаалд мэргэжлийн хүнийг томилж, улс төрчид, иргэний хөдөлгөөний хариуцлагыг өндөржүүлж зохицуулах шаардлагатай.
- Олон нийтэд үнэн, бодит, салбарын талаар эерэг ойлголтыг өгөх мэдлэг, мэдээлэл өгөх сургалт, сурталчилгаа, PR-ийн ажлыг тогтмол зохион байгуулах, салбарын мэргэжилтнүүдэд зориулж ашигт малтмал, байгаль орчин, газрын харилцаа болон бусад холбогдох хууль эрх зүйн орчны талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл, сурталчилгааг нэгдсэн байдлаар ил тод, энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргүүлдэг онлайн платформыг бий болгож, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байгаа хариуцлагагүй, хууль бус олборлолт хийдэг, нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлдэггүй иргэд, байгууллагын үйл ажиллагааг таслан зогсоох, хариуцлагыг хүлээлгэх ажлыг холбогдох хүчний байгууллагатай хамтран гүйцэтгэх.
- Аливаа гэнэтийн шийдвэр гаргахаас зайлсхийж, хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх, мэдээллээр хангаж ажиллах.
- Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай хүргэх үүднээс шаардлагатай мэдээллийг интернетийн орчинд байршуулж, тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрөл олгох ажиллагааны шат дарааллыг багасгаж, цахимаар өргөдөл хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх.
- Геологийн мэдээллийг цахимжуулж хөрөнгө оруулах сонирхолтой этгээдийг бодит мэдээллээр шуурхай хангаж, геологи хайгуулын ажлын хяналт, баталгаажуулалтын ажлыг сайжруулах тал дээр дэвшилтэт техник, технологийг ашиглаж, өндөр мэдлэг, туршлага бүхий хүмүүсийг оролцуулах боломжтой.
- Татварын орчны давхардал, бодит бус татвар ногдуулалт, тодорхойгүй байдлыг арилгахад анхаарч татвар, санхүүгийн холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, татварын орчныг таатай болгоход анхаарч ажиллах.